



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2023.04.13 № ЦМ-8/16

танай 2023.03.28 -ны № 14 -т

Сонгуульт гишүүдийн өөрчлөлт бүртгэсэн тухай

Танай хоршооноос 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр ирүүлсэн сонгуульт гишүүний өөрчлөлт бүртгүүлэх хүсэлт, холбогдох баримт бичгийг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 8.2-т заасны дагуу хянаж үзээд холбогдох бүртгэлд дараах өөрчлөлтийг бүртгэсэн болно. Үүнд:

№	Хамаарал	Овог, нэр	Тайлбар
1	Тэргүүлэгчдийн зөвлөл	Дарга	Б.Насанжаргал
2		Гишүүн	Ц.Цэрэнбат
3		Гишүүн	Б.Түмэнцогт
4		Гишүүн	С.Амархүү
5	Хяналтын зөвлөл	Дарга	Г.Энхтуяа
6		Гишүүн	Ж.Батсүх
7		Гишүүн	Г.Болортуяа
8	Зээлийн хороо	Дарга	Г.Баярсайхан
9		Гишүүн	Д.Оюунчимэг
10		Гишүүн	А.Уранчимэг
11	Гүйцэтгэх захирал	Г.Баярсайхан	бүртгэлтэй
12	Нягтлан бодогч	Д.Оюунчимэг	бүртгэлтэй

Тэргүүлэгчдийн зөвлөлийн шинэ гишүүн Х.Амарзаяа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хязгаарлалтыг зөрчиж, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3.3-т заасан шаардлагыг хангахгүй байгаа тул хоршооны сонгуульт ажлыг хаших боломжгүй байна.

Иймд хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гишүүнийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн сонгож, өөрчлөлтийг ажлын 10 хоногийн дотор Хороонд бүртгүүлэх шаардлагатайг үүгээр мэдэгдье.

